

Contents

- 2 日本語版
- 4 Bản tiếng Việt [ベトナム語版]
- 6 中文版 [中国語版]
- 8 Bersyon sa Pilipino [フィリピン語版]
- 10 Edisi Bahasa Indonesia [インドネシア語版]
- 12 ฉบับภาษาไทย [タイ語版]
- 14 ភាសាខ្មែរ [カンボジア語版]
- 16 မြန်မာဘာသာ [ミャンマー語版]
- 18 Монгол хэл дээрх хувилбар [モンゴル語版]
- 20 English Version [英語版]

こくごのもり

小学低学年の児童を対象に国語の楽しさを知ってもらおうと、イラストを多用してつくった問題で「毎日小学生新聞」に長期連載。

©毎日小学生新聞 複製、転用はできません

年のくれ・年のはじめをあらわす言葉をかこみましょう。

こくごのもり

指導・元世田谷区立
小学校教諭
高橋 伸子
イラスト・奈良 恵

年のくれ
年のはじめ

お	ね	お	と	し	だ	ま	ぶ	お	く	お	じ
せ	ん	か	が	み	も	ち	れ	お	り	お	よ
ち	が	か	た	こ	あ	げ	ぜ	み	す	そ	や
り	じ	き	は	ね	つ	き	ん	そ	ま	う	の
よ	よ	ぞ	お	ぞ	う	に	と	か	す	じ	か
う	う	め	か	る	た	と	り	ゆ	ず	ゆ	ね
り	は	つ	も	う	で	と	し	こ	し	そ	ぼ

答えはP22にあります。

Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр

2020 оны 1 дугаар сар, Өвлийн дугаар

ЈИТСО-гийн Япон хэлний зохион бичлэгийн танилцуулга

~Өмнөх уралдааны шилдэг бүтээл (“Хоёр дахь гэр бүл”)-ийн танилцуулга~

Олон нийтийн эрх ашгийн төлөө корпораци, Японы Олон улсын сургалтын хамтын ажиллагааны байгууллага (ЈИТСО) нь жил бүр “Ур чадварын дадлагажигч, сургалтанд хамрагдагч гадаад иргэдийн Япон хэлний зохион бичлэгийн уралдаан”-ыг зохион байгуулдаг ба Ур чадварын дадлагажигч та бүхнийг Япон хэлний зохион бичлэгийн уралдаанд оролцохыг урьдаг. Жил бүрийн 4 дүгээр сарын эхэнд тус уралдааныг зарладаг ба маш нарийн сонгон шалгаруулалтыг хийж, 10 дугаар сард шилдэг бүтээлийн шагналыг гардуулдаг. Мөн, уралдаанд оролцсон бүх оролцогчдод “Шилдэг бүтээлийн цомог”-ийг тараадаг.

Өнгөрсөн уралдаанд оролцсон бүтээлүүдийн дотроос 2018 онд “Шилдгийн шилдэг бүтээлийн шагнал”-ыг гардсан бүтээлийг та бүхэнд толилуулж байна. Ур чадварын дадлагажигчийн бичсэн бүтээлийн Япон хэл дээрх эхийг 2-р хуудсанд нийтэлсэн болно.

Ур чадварын дадлагажигч, сургалтанд хамрагдагч гадаад иргэдийн Япон хэлний зохион бичлэгийн уралдааны 2018 оны “Шилдгийн шилдэг бүтээлийн шагнал”-ыг гардсан бүтээл

Хоёр дахь гэр бүл

NGUYEN THI KIM LINH

Бид хоёр нөхөрлөж эхэлснээс хойш 2 жил өнгөрлөө. Тэмдэглэлт өдөр маань 2016 онд анх удаа Японд ирсэн өдөр юм. Тэр өдөр бид хоёр цаашид ямар ч юм тохиолдсон, хамтдаа хичээнэ гэж тохиролцсон. Баяр хөөрөөр дүүрэн, хамтдаа хөгжилтэй сайхан байна байх гэж бодож билээ. Гэвч, бодит байдал дээр бол, бодож байснаас хэцүү зүйлтэй зөндөө тулгарч, гунигтай зүйл, айдас хүрэхээр зүйл ч тохиолдож, заримдаа дургүй хүрээд болимоор санагдаж, шантрах үе ч гардаг л байлаа. Тиймэрхүү үед, өөрийнхөө сэтгэлийг барих дотор хүний минь дуу хоолой надад сонсогддог байсан. Амар хялбар шалтгаанаар шантрах нь буруу гэдгийг ойлгож, өнөөг хүртэл бид хоёрын харилцаа үргэлжилж ирсэн. Энэ хүртэл уншаад, хэнд ч гэсэн тэр хүн нь хэн юм бол гэж мэдэхийг хүсэх хүсэл төрөх болов уу гэж бодож байна. Хариулт нь, Япон гэдэг нэртэй хүн юм.

Яагаад өөрийнхөө нөхөрлөж байгаа хүнээ Япон гэж нэрлэж байгаа юм бол. Яагаад гэвэл, энд миний олон найз нар байгаа, ах, эгч, аав, ээж шиг хүмүүс ч байдаг, өөр бусад зөндөө олон хүмүүс миний хажууд хань болж байдаг болохоор юм. Энэ бүх хүмүүсийг өөрөөр юу гэж нэрлэвэл болохыг мэдэхгүй юм. Нэг мэдэхэд л, миний хоёр дахь гэр бүл болсон хүмүүс юм.

Гэр бүлийнхэнтэйгээ хамт байхад, янз бүрийн л юм тохиолддог. Баярлах юм ч тохиолдоно, гунигтай юм ч тохиолдоно.

Хамгийн гунигтай байсан нь, миний ажилладаг компаний дарга өөр ажлын байр руу шилжсэн явдал байв. Нийт 80 орчим дадлагажигч бид нарыг хариуцаж ажиллана гэдэг үнэхээр хүнд хэцүү ажил гэж бодож байна. Манай хоёр дарга хоёулаа бид нарын аав шиг л өдөр бүр бид нарыг харж хандаж байсанд сэтгэлийнхээ гүнээс маш их талархаж явдаг. Одоо гэр бүлийн минь гишүүдээс хоёр нь энд байхгүй байна. Миний хувьд хамгийн гунигтай зүйл энэ юм.

Баярлах юм зөндөө байна. Өдөр болгон бүгдээрээ ажлаа хичээнгүйлэн хийж байгааг нь харах боломжтой байгаа нь надад аз жаргал авчирдаг. Бүх хүчээ дайчлан ажиллаж байгаа эгч нар надад сэтгэлийн дэм өгдөг юм.

Би өдөр болгон ажилдаа ядарсан байсан ч, дотуур байранд нийтээр амьдрах амьдралаас үе үе залхсан ч, байнга инээмсэглэж явахыг хичээдэг. Миний хобби бол эргэн тойрныхоо хүмүүсийг инээлгэх. Уйтгар гунигийг хүнтэй хуваалцвал, талдаа хүртэл багасдаг, баяр баясгаланг хүнтэй хуваалцвал, хоёр дахин нэмэгддэг гэж хүнээс сонссон, энэ үнэхээр үнэн гэж бодож байна. Ямар ч юм байсан, гунигтай юм ч бай, баяр баясгалантай юм ч бай, өөрөө яаж бодохоос л хамаарна.

Хавар болохоор замаар зөндөө олон цэцэг дэлбээлж, зун болохоор ногоон зүлэг, модод ургаж, намар болохоор уул нуруу улаан өнгийн гоёлоороо гоёж, өвөл болохоор тэнгэрээс нүд гялбам үзэсгэлэнт цасан ширхгүүд хаялдаг. Хоёр дахь гэр бүлийн минь эргэн тойронд бүхий л өнгөнүүд байна. Энэ дүр төрхийг яагаад ч мартаж чадахгүй. Би Япон гэдэг энэ газарт дурлачихжээ.

Хэн ч гэсэн, цаг хугацааны эрхээр өөрчлөгддөг. Би ч гэсэн 2 жилийн өмнөхтэйгөө харьцуулвал, өөрчлөгдсөн байж магадгүй. Бага ч болов хөгжиж дэвшиж чадсан гэж бодож байна. Хоёр дахь гэр бүлтэйгээ учраад, би одоо ямар ч зүйлд өөрийгөө сорьж чадна. Хөх тэнгэр рүү тэмүүлэн урагшаа зүтгэнэ. Одоо миний ид залуу үе. Өөрийгөө хичээгээрэй гэж хэлье.

Жил бүр хүсэл эрмэлзлээр дүүрэн бүтээлүүд олноор оролцдог “Ур чадварын дадлагажигч, сургалтанд хамрагдагч гадаад иргэдийн Япон хэлний зохион бичлэгийн уралдаан”. 28 дахь удаагаа зохион байгуулагдах 2020 оны уралдааныг 2 дугаар сарын эхээр зарлах ба уралдааны удирдамжийг ЈИТСО-гийн цахим хуудсаар танилцуулахаар төлөвлөж байна. Та бүхнийг идэвхтэй оролцохыг урьж байна!

Гал гаргахаас сэргийлж, болгоомжтой байгаарай!

Японд өвлийн улиралд агаар хуурайшилттай байдаг ба гал түймэр амархан үүсдэг үе юм. Дотоод хэргийн яамны Гал түймэр, гамшгийн менежментийн агентийн судалгааны дүнгээс үзэхэд, 2018 онд гарсан байшин барилгын гал түймрийн гал үүссэн шалтгааны эхний 5-д “Газын плетка”, “Тамхи”, “Гал тавьсан”, “Халаалтын зуух”, “Цахилгааны утасны тоног төхөөрөмж” орсон байна. Ур чадварын дадлагажигч та бүхэн ч байрандаа хоол хийдэг, халаалтын зуух ашигладаг биз ээ. Японы засгийн газрын олон нийттэй харилцах онлайн алба-наас нийтэд мэдээлсэн “Орон сууцны гал түймрээс сэргийлэхэд анхаарах 7 гол зүйл”-ийг танилцуулъя. Уншиж танилцан, гал гаргахаас сэргийлж, болгоомжтой байгаарай.

Орон сууцны гал түймрээс сэргийлэхэд анхаарах 7 гол зүйл




Хичнээн сэргийлсэн ч, золгүй тохиолдлоор гал гаргачихсан тохиолдолд яавал зүйтэй юм бол? Бүс тус бүрийн Галын депо болон холбогдох байгууллагаас дараах үйлдлүүдийг хийхийг сануулж байна.

- ✓ Чанга дуугаар хэлэх, аваарын хонх ашиглах гэх мэт аргаар эргэн тойрондоо мэдэгдэх. Ойрхон байгаа хүн нь даруй 119 дугаараар дуудлага өгч, дуудлага хүлээн авагч нь “Гал гарсан уу? Түргэн тусламж шаардлагатай болсон уу?” гэж асуух бөгөөд “Гал гарлаа (Kaji desu)” гэж мэдэгдэх.
- ✓ Галын дөл тааз хүртэл тэлээгүй бол, гал унтраагуур болон бусад хэрэгслийг ашиглан, галыг унтраах.
- ✓ Гал гарсан газраас дүрвэх үедээ, агаарын урсгалын нөлөөгөөр гал улам нэмэгдэхээс сэргийлэхийн тулд, цонх, хаалгыг нь хаах.

Мэдээж, өөрийнхөө аюулгүй байдлыг хангах нь ч чухал. Шаардлага гарсан үед дээрх үйлдлүүдийг даруй хийж, мөн амжиж дүрвэхийн тулд, гамшгаас хамгаалах сургуулилалтанд хамрагдах зэрэг аргаар ердийн үед бэлтгэлтэй байх нь чухал юм.

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая, Япон хүний сэтгэл

— Галаас сэрэмжлээрэй (Hi-no yo-jin) —



Маруй сан, хариугүй гал гаргах дөхлөө.

Өвлийн улиралд гал ашиглах шаардлага нэмэгддэгийн зэрэгцээ агаар хуурайшилттай байдаг тул, гал түймэр амархан үүсдэг улирал юм. 2 модыг хооронд нь цохин дуу гаргаж, “Галаас сэрэмжлээрэй” гэж чанга дуугаар зарлаж сэрэмжлүүлдэг хөдөлгөөн Японы энд тэндгүй өрнөдөг. Мэдээж, дан ганц өвлийн улиралд бус, бүтэн жилийн турш галаас сэрэмжлэхэд анхаарцгаая.



年の暮れが近づきました。年納めや新年の準備の中で、いつもの休みとは違う「あらたまる」行事のあるのが冬休みでしょう。

年の暮れ、年の瀬、歳末、大みそか、除夜と年の夜（どちら也大みそかの夜）など、多くの言葉とともに、今年を無事に過ごせたことをよろこびたいですね。

Cuối năm đang lại gần. Để chuẩn bị cho dịp cuối năm và đầu năm, chắc hẳn có nhiều việc mới mẻ vì vậy dịp nghỉ Đông cũng là thời điểm khác với các dịp nghỉ khác đúng không các bạn.

Cứ độ cuối năm ta lại gặp nhiều từ tiếng Nhật như: 年の暮れ- Toshinokure, nghĩa là cuối năm, 年の瀬- toshinose, nghĩa là giai đoạn bận nhất trong năm, 歳末- saimatsu, cũng có nghĩa là cuối năm, 大みそか=ohmisoka, nghĩa là tất niên, 除夜-joya, nghĩa là đêm trừ tịch, tức giao thừa và 年の夜- toshinoyo, cũng có nghĩa là giao thừa. Chúc tất cả các bạn một năm mới bình an vô sự.

临近年末，在年终和新年的准备过程中，和平常的休假不同，有「更新」之意的节庆活动的才是寒假吧。

年の暮れ、年の瀬、歳末、大みそか、除夜和年の夜（都是除夕的晚上）等，和这么多的词汇一起来庆祝今年平安地度过吧。

Papalapit na ang katapusan ng taon. Sa panahon ng taunang bayaran at paghahanda para sa Bagong Taon, ang mga piyesta opisyal sa winter ay mayroong "bagong" kaganapan na naiiba sa karaniwang mga piyesta opisyal. May mga salitang "年の暮れ=toshinokure", "年の瀬=toshinose", "歳末=saimatsu", "大みそか=ōmisoka", "除夜=joya" at "年の夜=toshinoyo" (lahat ng ito ay ang gabi bago sumapit ang bagong taon), at iba pa at kasabay ng mga salitang ito ay nais nating ipaalam na ikatutuwa natin na matapos ang taon ng ligtas sa anuman.

Akhir tahun sudah semakin dekat. Di tengah pekerjaan akhir tahun dan persiapan tahun baru, terdapat acara "menjadi baru" yang berbeda dengan liburan biasa, yaitu liburan musim dingin.

Dengan banyak ucapan seperti 年の暮れ, 年の瀬, 歳末, 大みそか, 除夜 dan 年の夜 (keduanya merupakan malam tahun baru), kita ingin bersyukur karena telah melewati tahun ini dengan selamat.

ใกล้จะสิ้นปีแล้ว ในระหว่างการปิดท้ายปีและเตรียมพร้อมสำหรับปีใหม่ เทศกาลแห่ง "การเปลี่ยนแปลง" ทำให้วันหยุดในฤดูหนาวแตกต่างจากวันหยุดทั่วไป

พร้อมกับหลากหลายคำที่ใช้เรียกคืนส่งท้ายปีเก่า 年の暮れ, 年の瀬, 歳末, 大みそか, 除夜 และ 年の夜 (ทุกคำล้วนหมายถึงคืนวันสิ้นปี) เป็นคืน ช่วงเป็นเวลาที่เราน่าสนใจที่เราสามารถข้ามผ่านปีนี้ได้โดยสวัสดิภาพ

ចុងឆ្នាំជិតចូលមកដល់ហើយ។ ថ្ងៃឈប់សម្រាកដូចមានព្រឹត្តិការណ៍«ចាប់ផ្តើមជាថ្មី» ដែលខុសគ្នាពីថ្ងៃឈប់សម្រាកធម្មតា ហើយក៏ជាអំឡុងពេលនៃការបញ្ចប់ការងារឆ្នាំចាស់ និងការរៀបចំសម្រាប់ឆ្នាំថ្មី ផងដែរ។ ខ្ញុំរីករាយណាស់ដែលអាចឆ្លងមួយឆ្នាំនេះដោយសុខសប្បាយ ដែលថ្ងៃឆ្លងឆ្នាំ គេអាចប្រើពាក្យនិយាយជាច្រើនដូចជា 年の暮れ、年の瀬、歳末、大みそか、除夜 និង 年の夜 (ទាំងអស់នេះសុទ្ធតែមានន័យថាឈប់ថ្ងៃឆ្លងឆ្នាំ) ។

နှစ်ကုန်ခါနီးပါပြီ။ နှစ်ဟောင်းမှာ လက်ဝဲသတ်စရာတွေ၊ နှစ်သစ်အတွက် ပြင်ဆင်စရာတွေနဲ့ ပုံမှန် အားလပ်ရက်တွေနဲ့ မတူဘဲ "အသစ်ကူးပြောင်းမှု" ဝုန်းတမ်းစဉ်လာ လုပ်စရာတွေရှိတဲ့ ဆောင်းရာသီ အားလပ်ရက် ဖြစ်ပါတယ်။

年の暮れ、年の瀬、歳末、大みそか、除夜 年夜 (နှစ်ခုစလုံး နှစ်သစ်ကူးည) လို စကားလုံးတွေနဲ့ နှစ်သစ်မှာ အေးချမ်းစွာနေထိုင်နိုင်တာ မင်္ဂလာပါ။

Хуучин оноо үдэх сүүлийн өдрүүд дөхөж байна. Хуучин оноо үдэх болон шинэ оноо угтах бэлтгэлээ базаах энэ үе бол ердийн амралтаас өөр бөгөөд "Шинээр эхлүүлэх" зүйлстэйгээрэй ялгаатай нь өвлийн амралтын онцлог биз ээ.

年の暮れ、年の瀬、歳末、大みそか、除夜 болон 年の夜 (Аль аль нь "Хуучин оноо үдэх сүүлчийн орой") гэх мэт олон үг хэллэгийн хамт, үдэж буй оноо эсэн мэнд өнгөрөөж чадсандаа баярлацгаа.

The end of the year is just around the corner. Among the preparations for bidding farewell to the old year and ushering in the new, you may notice that winter vacation is full of "formal" events, unlike other holidays. By reflecting back on your year along with words of the season such as 年の暮れ, 年の瀬, 歳末, 大みそか, 除夜 and 年の夜 (both referring to New Year's Eve), we hope you are filled with a warm feeling of having spent the year safely without incident.

技能実習生・研修生向母国語情報誌

技能実習生の友

2020年1月 冬季号

2020年1月1日発行

発行

電話

JITCO ホームページ

公益財団法人 国際研修協力機構 (JITCO)

総務部広報室

〒108-0023

東京都港区芝浦 2-11-5

五十嵐ビルディング

03-4306-1166 (ダイヤルイン)

https://www.jitco.or.jp/